

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сандуйн Наваандагва	Дугаар	L097
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Галшар сум
Төрсөн газар	Галшар сум	Төрсөн он	1915
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хужиртын хийд, Хардэлийн ганжуур, Зодын хурал	Сүм хийдийн дугаар	ХЭГЛ 054, ХЭГЛ 046, ХЭГЛ 047
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Галшар сумын Хужиртын хийд, Хардэлийн ганжуур, Зодын хурал

-Та нутаг орондоо байсан өөрийн мэдэх сүм хийдийн талаар ярьж өгнө үү?

Буянт сумд Хардэл бэйсийн хийд гэж байсан уу?

Хуучин Буянт, Галшар хоёр гэдэг чинь Галшар чинь татан буугдаагүй байсан юм.

Хэд хэдэн дуган байсан юм.

-Хардэлийн Ганжуурын хийд гэж байсан уу?

Байсан. Гол дуган, Цогчэн дуган, Ганжуурын дуган гэж байсан. Пэлжээлин гэдэг дуган, Дашпэлжээлин гэдэг дуган байсан даа. Лаврин гэж одоо суварганы хойхно байна уу, зүүхэнтээ хоёр хөөрхөн сүм байсан юм.

-Яг тэд нар нь тус тусдаа хурлын газар байсан уу?

Тус тусдаа хуралтай, тус тусдаа жастай байсан. Тус тусдаа няравтай, гэсгүйтэй, ламтай байсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.  
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Та аль хийдэд нь шавилан сууж байсан бэ?

Би хойно Хужирт дээр байсан. Хошуу дөрвөн аймаг гэж дөрвөн отгийн дуган, гол Цогчэн дуган нийлээд 5 дацан байсан. Нэлээн олон дуган дацан байсан. Дөрвөн аймаг гэж дөрвөн отгийн лам нар байдаг. Голбог, Дайчин отог, бага хардэл отог, гол отог гэсэн дөрвөн отог байдаг байсан. Гол отог гэж ноёдын юмыг бэлддэг тийм отог байсан. Дайчин гэдэг нь хошууны нэг отог байсан. Бага хардэл гэдэг нь хошууны алба хийдэг отог.

-Хужиртын хийдийн нэр нь төвдөөр юу гэдэг байсан юм бэ?

Ганданшадавдаржаалин гэдэг байсан юм.

-Та өөрийн сууж байсан Хужиртын хийдийн тухай яриач? Хэдэн онд хэн гэдэг хүний санаачлагаар барьсан бэ?

Зуугийн сүм, Ганжуурын сүм, Данжуурын сүм гэж туйпуун дуган байсан. Данжуурын сүмийг буулгаж 25 тохой өндөр Майдарын сүмийг босгосон.

-Хужиртын хийдэд ямар ямар дуганууд байсан бэ?

Чойр дуган, Тэгчинлэн, Жүд, Зурхай, Манба гэсэн дуган байсан. Манба дуган гэдэг маань эмнэлгийн дуган, Зурхай дуган гэдэг маань зурхай шинжилгээний дуган. Жүдийн дуган гэдэг маань уншаач унзад нарыг бий болгож байсан дуган.

-Нийтдээ хэдэн дуган байсан бэ?

Нийтдээ 10 гаруй дуган байсан байх. 4 аймгийн дуган, таван сүмийн дуган, Цогчэн дуган, Гол Ганжуур дуган, Дүйнхорын дуган, ноёдын шүтээн гэж хоёр сүм байсан юм.

Гол Цогчэн дуган гэж нэлээн том. Баруун хаяанд нь суухад зүүн хаяанд нь сууж байсан хүний нүүр танигддаггүй тийм том байсан.

-Ойролцоо ямар хийдүүд байсан бэ?

Баянхааны энгэрт Зүүн Ганжуур гэж байсан. Зүүн хойно Банди ламын хийд гэж байсан юм. Дайчин Ганжуур гэж баруунтаа Үнээгийн энгэр дээр байсан. Буянтын Ганжуур гэж энд байсан. Дээр.

-Цанын Ганжуур гэж байсан юм үү?

Хийд бүр Ганжууртай байна л даа. Отгийн хурлууд дандаа Ганжууртай. Дайчин Ганжуур, Буянтын Ганжуур, Хардэлийн Ганжуур гэж байсан.

-Хужиртын хийд таныг шавилан сууж байхад хэдэн ламтай байсан бэ?

2000 аад юм байсан байх. 1000 ламын данстай гэдэг байсан байх.

-Ямар ямар онцлог хуралтай байсан бэ?

Цагаан сарын шинийн нэгнээс эхлээд 15 хоног ерөөл гэж хурна. Тэгээд зуны адаг сарын 10-нд Аравны Ганжуур гэж хурна. Сар бүрийн 18-нд Санжид чого гэж хурдаг. Аймгуудын хурал бол жилдээ 10, 10-аад хоног хурдаг хуралтай байсан. Чойр дацан бол 4 удаа сарын хуралтай, 2 удаа 20 хоногийн хуралтай, 2 удаа 15 хоногийн хуралтай байсан. Манба дацан дүлцэнтэй, бас нэг 10-аад хоногийн хуралтай байдаг байсан.

-Дүлцэн хийдэг нь Дүйнхор дацан биш үү?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дүйнхор дацан гэдэг чинь зун нэг хэд хоногийн хуралтай байсан мэдэхгүй. Жүд дацан гэдэг чинь сар бүрийн хуралтай. Жүдэд чинь аграмба болдог. Чойрт гавж болдог тийм байсан.

-Цам гардаг байсан уу?

Байхгүй. Манай Бандид ламын хийдэд цам гардаг байсан. Буянт дээр цам гарч байгаад сүүлдээ тэгээд байхгүй болсон. Өөр манай хошуунд цам гардаг хийд байгаагүй.

-Майдар хэдүйд эргэдэг байсан бэ?

Зуны адаг сарын байх аа 11-нд Майдар эргэнэ. 10-нд Ганжуур гэж хураад 11-нд Майдар эргээд, 11-ээс эхлээд Маанийн бүтээл 7 хоног хурдаг байсан.

-Өөр онцлох хурал ямар байсан бэ?

Өвлийн адаг сарын 26-аас эхлээд хуучин хурал хурна. Хангал хурна. 29-д Чойжоогийн сор залдаг байсан. Цагаан сарын 29-нд газар бүр л сор залдаг байсан.

-Төвд лам залдаг байсан уу?

Манай хийдэд төвд лам байгаагүй байх аа.

-Хүрээнээс лам, багш залдаг байсан уу?

Хүрээний лам ирдэг байсан. Хөдөө баруун хойно хувилгаан төвд гэдэг хүн байсан. Төвд хүн байгаагүй байх аа. Тэгж ярьдаггүй байсан.

-Уул овооны тахилгын судраа бичдэг байсан биз дээ? Ном судар бичиж байсан лам нар байсан уу?

Байхгүй байх аа. Уул овоогоо тахихдаа Хошууны том том лам нар оролцдог байсан.

-Хийдийн жас нь хаанаа байдаг байсан бэ?

Жас газар газар байна л даа. Мал нь хөдөө айлд айлд байдаг байсан. Адуу үхэр хонь мал бүр байсан. Гол Ганжуур олон суурь адуутай отог байсан. Шар Раднаа, Гончиг, Намжилдагва гэдэг хүмүүс малыг нь маллаж байсан. 4 суурь адуу байсан. Хонь мал олонтой. Ганжуур жас гэдэг чинь баян жас байсан. Олон тэмээтэй. Аян жинд үргэлж явдаг байсан. Бага Хардэлд Хорол баян гэж их баян хүн байсан юм гэнэ лээ. Түшмэл хүн байсан.

-Таны сууж байх үеийн дацангуудын хамба, гэсгүй, унзад нарын нэрийг хэлээч?

Янз янзын улс байсан. Тэгээд 1927 (1937) оноос эхлээд баригдсан л даа.

1937 оны намраас эхэлж баригдсан.

Хийдийн хамба нь Тавхай цорж гэдэг хүн байсан. Дээр үедээр Яндаг цорж гэж байсан гэсэн. Мөн Дамдингомбо цорж гэж байсан. Тэгээд Наваан гуай байсан.

-Цогчэн унзад нь хэн хэн гэдэг хүн байсан?

Наваан гуай л байсан байх.

-Цогчэн гэсгүй нь хэн гэдэг хүн байсан бэ?

Гэсгүй нь одоо Гончиг байсан болов уу, Дамбийням, Гончиг энэ тэр байсан байх аа. Жамбаноровын дүү тарган Гончиг гэдэг гэсгүй байсан.

-Чойр дацангийн шунлайв нь хэн гэдэг хүн байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чойр дацангийн шунлайв Равдан гуай байсан.

-Чойр дацангийн унзад нь хэн байсан бэ?

Чойр дацангийг унзад чинь хүн хүн л байсан л даа. Мархиу Жанжаа, Дамбын Нуваанчүлтэм, Ядамын Хужгар Лувсанцэрэн гэсэн улсууд байсан л даа.

-Тэр Жүд, Манба дацангийн шунлайв хэн байсан бэ?

Жүдийн ламыг ловон гэнэ. Дамбий гуай байсан. Манбын ламыг Манба лам гэнэ. Тусгай тусгай нэртэй. Манба лам гэдэг нь Рэгдэл гуай байсан байх. Зурхайн лам гэдэг чинь Дархан Дамдингийн ах Сүхийн Наваандаш гэдэг лам байсан.

-Ганжуур дацангийн лам нь хэн хэн байсан бэ?

Баруун Ганжуурын лам Нэрэн Гомбо, Наваан гуай энэ тэр байсан. Нэрэн Гомбо гэдэг нь Манан Шагдарын ах лам. Наваан гуай гэдэг нь Хөх Чойдолын ах лам.

-Зүүн Ганжуурынх нь хэн байсан юм бэ?

Бүдшар гэж хүрээнд сууж байсан нэг лам байсан. Жижиг Лхагвын ах.

-Та өөрөө аль дацанд нь хурж байсан бэ?

Чойр дацанд хурдаг байсан.

-Хэдэн настай шавилан суусан бэ?

10 хэдтэй л байсан байгаа.

-Чойр дацанд хэдэн жил хурсан бэ?

17, 18-тай Чойрт хураад 22, 23-той баларсан.

-Таныг аль зиндаанд байхад Чойр дацан баларсан бэ?

Мэдэхгүй ээ, намайг Чойрт ороход гэсгүй нь хэн байсан юм мэдэхгүй.

-Та Чойр дацанд байхдаа аль зиндаанд ямар ном үзэж байсан бэ?

Чойрын ном гээд эхний Ондогжин, Уманжүг гээд тийм ном үзэж байсан. Дагсал энэ тэрийг нь үзэж чадаагүй.

-Яг Чойр дацандаа хэдэн лам хурж байсан бэ?

Чойрт 100-аад шахуу лам байсан байх.

-Та аль зиндаа хүртэл явсан бэ?

Чойр дацан гэдэг чинь анхан ороод дом хийж дээшлүүлнэ. 9 жил болоод дом хийдэг. За тэгээд 10-аад жил болоод гавж болдог тийм байсан юм шүү.

-Та хэдэн жил болсон юм бэ?

Би 6, 7 жил болсон. Дом хийж чадаагүй. Дуганч, зарлага хийж байгаад өнгөрсөн.

-Таны зиндаанд хэдэн лам байсан бэ?

10 хэд 20 шахуу юм байсан байх. Одоо бараг байхгүй болсон байх аа. Чүлтэм унзадын Агваан гээд хотод нэг хүн байна уу, үгүй юу.

-Танай зиндааны багш, жорвон нь хэн хэн байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жорвон гэдэг нь толгойлогч гэсгүй гэсэн үг. Сэрчингийн Лувсанравдан гэдэг хүн байсан.

-Зиндааны багш чинь хэн байсан бэ?

Омболувсанравдан гэдэг хүн байсан. Омбо гэсгүй гэж байсан.

-Хамгийн сүүлд танай зиндаанд ямар ном хөтөлсөн бэ?

Аа мэдэхгүй.

-Манба дацандаа маарамбын дом тавьдаг байсан уу?

Мэдэхгүй.

-Дацангуудын тус тусын сахиуснууд ямар ямар сахиус байсан бэ?

Хошуу нь Гомбо сахиустай. Чойр нь Гомбо сахиустай байсан. Жүд нь Санж Чүсэм сахиустай байсан. Манба нь Чойжоо сахиустай байсан. Дүйнхор гэж цөөхөн ламтай, баруун хойно Гол Ганжуурт хурдаг байсан. Дүйнхорын лам нар чинь гол отгийн лам нар байсан юм.

-Нийт Ядам нь юугаар ядамладаг байсан бэ?

Лхам Жүсэм, Жигжид ядамладаг байсан.

-Хийдэд тогтмол лам нар суудаг байсан биз дээ?

Хөдөө гэргүй, эцэг эх нь үрэгдсэн лам нар хийдэд байнга суудаг байсан уу?

- Хужиртын хийдээс ямар ямар уул овоог тахидаг байсан бэ?

Галшарыг тахидаг байсан.

-Галшарын тахилгын судар гэж бий юу?

Мэдэхгүй. Би бага байсан болохоор ямар судар уншиж байсныг мэдэхгүй. Галшарын өөрийн Галшар сан гэж байсан юм уу, үгүй юм уу мэдэхгүй. Рэнчинпагма сан гэдгийг уншаад байдаг болтой байсан.

-Хужиртын хийд маань яг ямар нэртэй газар байсан бэ?

Хужирт гэдэг газар байсан.

-Тойрсон ямар уул, овоо, ус байсан бэ?

Булан гэж бий. Хужиртын усны баруун толигорыг хэлдэг. Баруун талдаа ширээ дэнжтэй. Зүүн хонхорт нь Хужиртын хийд гэж байсан.

-Хужиртын хийд хэдэн онд хаагдсан бэ? Лам нарыг барьсны дараа хийдээ хаасан уу? Хийдээ хаачихаад лам нарыг барьсан уу?

Хужиртын хийд одоо мэдэхгүй юм аа. Би сайн мэдэхгүй байна.

-Бүх лам нар нь баригдсан уу? Баригдаагүй мяндагтан байсан уу?

Одоо мэдэхгүй ээ.

-Хийд хаагдах үед та хаана байсан бэ?

Баруун урд аймгийн нүүрний гудамжны зүүн үзүүрт байдаг байсан. Би нэг ах лам байсан. Тэндээ суудаг.

-Хийд нураагдсан хаагдсан он сарыг мэдэж байна уу?

Мэдэхгүй ээ. Нарийн мэдэхгүй болсон юм билээ. Уг нь мэдэж л байсан. Мартчих юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хийдийн ном сахиус, шүтээнийг нь яасан бол?

Яасан юм бол доо. Мэдэхгүй байна.

-Хийдийн гар зураг байдаг уу?

Байгаагүй байх аа.

-Өөр энэ хийдийн тухай таны санаж байгаа зүйл юу байна?

Одоо энэ хийдийг мэдэх хүн байхгүй болсон.

-Одоо энэ Галшарын бусад хийдүүдийн тухай мэдэх хүн байна уу?

Ишдоо гэдэг хүн аймагт байдаг.

-Та хар болсноосоо хойш юу юу хийсэн бэ?

Мал маллаж, жин тээж Эрээнцав орж байсан. Тэмээний хамар чангааж нэлээн ажил хийсэн.

-Буянт сум хуучнаар хошуунд орж байсан бэ?

Мэдэхгүй.

-Ямар ноёны хошуу гэдэг байсан бэ?

Галшарын хошуу. Хардэл гэж хошууны нэг отог. Хардэл бэйсийн хошуу 3 сум, хоёр хамжлага зүүн 5 баг байсан.

-3 сум гэдэг нь ямар ямар сумууд байсан бэ?

Дайчин сум, Гол хамжаа сум, Буянт сум гэсэн 3 сум байсан. Галшарын хийд сумын төвд байсан. Буянт сумын Зодын хурал Зүүн хаданд бий. Малын нядалгаа хийж байсан газар. Галшарын Зодын хурал гэдэг нь баруун хойно нь байсан байх